



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 4/21

Улаанбаатар хот

┌ Сургалт зохион байгуулах тухай ┐

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.4.5 дахь заалт, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3, 3.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Нийслэлийн нутаг дэвсгэрт байршилтай ресторан, зоогийн газруудын удирдах ажилтан, менежерүүдэд зориулсан “Рестораны менежерийн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх”, “Зөөгчийн ур чадвар” сургалтуудыг зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, зарцуулах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Сургалтын төсөв болох 240.000 /хоёр зуун дөчин мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч П.Ариунаад зөвшөөрсүгэй.

Гурав. Сургалтыг удирдамжид заасан хугацаанд зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн Ш.Ундармаад үүрэг болгосугай.

Хавсралт ... хуудастай

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын
2015 оны 03 сарын 19 ний өдрийн 421 тоот
тушаалын нэгдүгээр хавсралт

**“РЕСТОРАНЫ МЕНЕЖЕРИЙН МЭДЛЭГ, УР ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ” ,
“ЗӨӨГЧИЙН УР ЧАДВАР” СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ**

Зорилго: Нийслэл хотын ресторан, зоогийн газруудын үйлчилгээний чанар, менежер болон ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох боломжийг олгоход энэхүү сургалтын зорилго оршино.

Хамрах хүрээ: Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй ресторан, зоогийн газруудын менежер, зөөгч нар хамрагдана.

Зохион байгуулагчид: Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Монголын ресторан, зоогийн газрын холбоо.

Хугацаа: “Рестораны менежерийн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх” сургалт 2015 оны 03-р сарын 11-ний өдөр 09.30-16.30 цагт, “Зөөгчийн ур чадвар” сургалт 06-р сарын 13-ны өдрийн 09.30-16.30 цагт болно.

Хүрэх үр дүн: Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа ресторан, зоогийн газруудын үйлчилгээ, стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдал, найрсаг харилцааны түвшинд ахиц гарна.

Хаана болох: Нийслэлийн Аялал жуулчлалын газрын Сургалтын танхимд

Сургалтын хөтөлбөр:

“Рестораны менежерийн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх” сургалт

д/д	Сургалтын сэдэв	Хугацаа	Заах багш
1	Бүртгэл	09.00-09.50	
2	Сургалтын нээлт	09.50-10:00	МРЗГХ-ны ерөнхийлөгч доктор, профессор Д.Гансүх
3	“Рестораны хөгжил ба орчин үеийн чиг хандлага”	10:00-11:20	МРЗГХ-ны ерөнхийлөгч доктор, профессор Д.Гансүх
4	Үйлчилгээний ажилтнуудын мэдлэг ур чадварын хөгжил”	11:20-12:30	МИУС-ийн БС-ийн үйлчилгээний хөтөлбөрийн ахлах, МУ-ын зөвлөх инженер М.Билэгсайхан
5	Үдийн цай	12:30-13:20	

6	МРЗГХ-ны товч танилцуулга	13:20-13:40	Холбооны гүйцэтгэх захирал Ж.Лхагва-Эрдэнэ
7	“Рестораны үйлчилгээ ба хоол үйлдвэрлэлийн асуудлууд”	13:40-14:40	МУ-ын зөвлөх инженер Г.Хайсандай
8	“Зөөгч ба үйлчлүүлэгчтэй ажиллах арга ажиллагаа”	14:40-15:40	Мэргэшсэн зөөгч нарын клубын тэргүүн Н.Баттулга
9	“Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн танилцуулга	15:40-16:00	НАЖГ-ын Жуулчны аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн М.Баасандорж
10	Сургалтад оролцогчдод гэрчилгээ гардуулах	16:00-16:30	НАЖГ-ын Жуулчны аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн М.Баасандорж МРЗГХ-ны ерөнхийлөгч доктор, профессор Д.Гансүх

“Зөөгчийн ур чадварыг хөгжүүлэх” сургалт

д/д	Сургалтын сэдэв	Хугацаа	Заах багш
1	Оролцогчдын бүртгэл	08.50-09.00	МРЗГХ
2	Сургалтын нээлт	09.00-09.10	НАЖГ, МРЗГХ
3	“Зөөгчийн ур чадвар”	09.10-10.30	МУИС-ийн Бизнесийн сургуулийн Үйлчилгээний хөтөлбөрийн ахлах, дэд профессор МУ-ын зөвлөх инженер М.Билэгсайхан
4	“Зөөгч ба борлуулагч”	10.35-12.00	Монголын мэргэшсэн зөөгч нарын клубын тэргүүн Н.Баттулга
5	Үдийн цай	12.00-13.00	
6	“Цэстэй ажиллах арга ”	13.00-14.00	Монголын мэргэшсэн зөөгч нарын клубын тэргүүн Н.Баттулга
7	“Зөөгчийн мэргэжлийн чиг хандлага ба үүрэг оролцоо”	14.00-15.30	МРЗГХ-ны тэргүүн, доктор, профессор Д.Гансүх
8	МРЗГХ-ны үйл ажиллагаа “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн танилцуулга	15.30-16.00	НАЖГ, МРЗГХ
9	Гэрчилгээ гардуулах үйл ажиллагаа /Хаалт/	16.00-16.30	НАЖГ, МРЗГХ

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын
20... оны ... сарын ...-ний өдрийн тоот
тушаалын нэгдүгээр хавсралт

“РЕСТОРАНЫ МЕНЕЖЕРИЙН МЭДЛЭГ, УР ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ”,
“ЗӨӨГЧИЙН УР ЧАДВАР ” СУРГАЛТЫН ТӨСӨВ

№	Зардлын зүйл	Тоо	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Бүгд үнэ /төгрөг/
1.	“Рестораны менежерийн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх” сургалтын багшийн зардал	4	30000	120,000
2	“Зөөгчийн ур чадварыг хөгжүүлэх” сургалтын багшийн зардал	4	30000	120,000
	НИЙТ			240,000

ТӨСӨВ ЗОХИОСОН:
НАЖГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

Ш. Ундармаа

Ш.УНДАРМАА
2015 оны 03.-р сарын 19 өдөр

ХЯНАСАН:
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

П.АРИУНАА
2015 оны 03.-р сарын 19 өдөр